

ЗӨРЧЛИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Д.Батцогт

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн дэд профессор, хурандаа

Товч агуулга: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь эрүү, иргэн, захиргааны хэргийн талаар хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэж, улмаар гэм буруутай этгээдийн эрхийг хязгаарлах, дахин гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байсан. Эрх зүйн орчны өөрчлөлтийн явцад 2017 онд шинэчлэн баталсан Зөрчлийн тухай хууль хэрэгжиж, зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг биелүүлэх шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг явуулах болсон. Үүнтэй холбогдуулан Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны удирдлага зохион байгуулалтын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, цаашид сайжруулах арга замын тодорхойлоход оршино.

Abstract: The judicial decision-making body had the function of executing effective court decisions on criminal, civil, and administrative cases in accordance with the relevant laws and regulations, thereby restricting the rights of guilty parties and implementing activities aimed at preventing them from re-offending. In the course of changes in the legal environment, the Law on Violations, which was newly approved in 2017, was implemented, and enforcement activities were carried out to fulfill court decisions on violations. In this regard, the management of the operation of the enforcement of the violation decision is to analyze the current state of the organization and determine the ways of further improvement.

Түлхүүр үгс: Зөрчил, үйлдэл эс үйлдэхүй, хариуцлага

Key words: Violations, omissions and liability

Нийгмийн хувьсан өөрчлөлт, хүмүүс хоорондын цаг үеийн өөрчлөлтийг даган харилцааны олон төрлөөс шалтгаалан зөрчилдөөн тодорхой хэмжээгээр үүссээр ирсэн. Аливаа улс орны төрийн үүрэг нь нийгмийн харилцааг зохицуулах хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, түүнийгээ хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянах, буруутай этгээдэд хариуцлагын тогтолцоог бий болгох үйл ажиллагааг

системтэйгээр зохион байгуулах юм. Эрх зүйн орчны бүрдүүлэх түүхэн хөгжлийн явцад гэмт хэрэг гэж тооцож байсан үйлдэл эс үйлдэхүйг нийгмийн хөгжлийн өөрчлөлттэй уялдуулан ялын бодлого өөрчлөгдөж байна. Төр иргэдийн эрхийг хангах, нийтийн эрх ашгийн төлөө иргэдийн зарим үйлдэл, эс үйлдэхүйг хориглох, хязгаарлах арга хэмжээг авч буйн илрэл юм. Өөрөөр хэлбэл нийгэмд учруулж буй хор

уршгийн хэмжээ, үр дагавраас шалтгаалан гэмт хэрэг, зөрчил гэх хоёр ухагдахууныг ялган зааглаж, тэдгээрт оногдуулах хариуцлагын тогтолцоо ялгамжтай байлгах нь шударга ёсны зарчимд нийцэхүйц зохицуулалт гэж үзэж байна.

Олон улсад хорих ялыг хэрэгжүүлэхээс татгалзах чиг хандлагыг баримталж байгаа учир Монгол улс гэмт буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагын бодлогыг илүү уян хатан, хүмүүнлэг, энэрэнгүй ёсны зарчимд нийцүүлэн хуульчилж, 2017 онд шинэчлэн баталсан Зөрчлийн тухай хуулийг зайлшгүй судлах нь зүйтэй гэж үзлээ.

Тиймээс өнөөгийн Монгол улсад мөрдөж байгаа Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилт нийгэмд хэр үр дүнтэй байгааг мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн орчин, практик ажиллагааны туршлагад тулгуурлан цаашид сайжруулах шаардлагатай асуудлыг дэвшүүлэн илэрхийлэхийг зорьж энэхүү илтгэлийг бичлээ.

Үндсэн хэсэг

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын гүйцэтгэх чиг үүргийн нэгэн төрөл болох Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар судлахын тулд нэр томьёо, түүхэн уламжлалаас улбаалан судлах нь зүйтэй.

Зөрчил гэдэг үгийг шинжлэх ухааны салбар мэргэжилтэнгүүд харилцан адилгүй утга агуулгаар тайлбарлаж үздэг. Тухайлбал:

- Эдийн засагчид- Өрсөлдөөн
- Сэтгэл судлаачид-хүндрэл бэрхшээл, сэтгэл санааны хямрал
- Менежментийн шинжлэх ухаанд- асуудлыг шийдвэрлэх гарц, шийдэл, хувилбар гэх мэт.

Зөрчил гэдэг нь “conflictus” гэх латин үгнээс гаралтай, Монгол хэлний тайлбар толинд “зөрчих үйлийн нэр, харилцан харшлах, үл тохирох эсрэг тэсрэг явдал”⁴⁸, Оросын эрдэмтэн социологич А.Г.Здравомыслов “хүмүүсийн нийгэм дэх харилцан үйлчлэлийн маш чухал тал бөгөөд нийгмийн эд эс юм. Энэ нь нийгмийн амьдралын бдоитой болон байж болох субьектын хоорондын харилцааны хэлбэр бөгөөд тэр тохиолдолд тэдний сэдэл нь эсрэг тэсрэг үнэт зүйлс, хэм хэмжээ, сонирхол хэрэгцээгээр өдөөгдөж байдаг”⁴⁹ хэмээн тайлбарласан байдаг. Харин эрх зүйн зөрчил нь “Delict” буюу латин хэлний “delictum”⁵⁰ гэсэн эрх зүйн суурь зарчимт нэр томьёоноос үүсэлтэй гэж үздэг байна.

Аливаа төрлийн харилцаа хоёр ба түүнээс дээш оролцогчтой байх бөгөөд нэг талын тодорхой үйл ажиллагаагаар нөгөө талын эрх ашиг, байр суурь хөндөгдсний улмаас харилцаанд зөрчил үүсэх буюу

⁴⁸ Монгол хэлний тайлбар толь <http://mongoltoli.mn>

⁴⁹ Ю.Оюунаа Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа УБ., 2021. 7 дахь тал

⁵⁰ Мөн тэнд 8 дахь тал

талуудын харилцаан дээр асуудал үүсэж байгаа нь зөрчлийн шинж чанарыг агуулж байгаа юм. Гагцхүү учруулах хор уршгийн хэмжээ хязгаараар гэмт хэргийн шинж чанарыг агуулж байгаа эсэхээс шалтгаалан аль хуулиар зохицуулагдах нь тодорхой болгох үүднээс үйлдэл эс үйлдэхгүйг төрөлжүүлэн тогтоож өгөх нь хуулийг ойлгомжтой нэг мөр ойлгох боломжийг бүрдүүлнэ.

Зөрчил нь дараах шинжүүдийг агуулсан байна.

- Үйлдэл эс үйлдэхүй
- Эрх зүйн хэм хэмжээний эсрэг чиглэсэн байна
- Гэм буруутай байна
- Нийгэмд хор аюултай байна

Монгол улсад Захиргааны хариуцлагын тухай хууль 1992 онд батлагдан гарах хүртэл янз бүрийн хүчин чадал бүхий хууль тогтоомж, эрх зүйн актаар захиргааны хариуцлага хүлээлгэдэг байсан. Захиргааны хариуцлагын тухай хууль нь 1992 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр батлан гаргаж, мөн оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс мөрдөгдөж эхэлсэн 3 бүлэг 56 зүйлтэй хууль нь эрх зүйн анхдагч үндэс суурь болсон юм. Цаг хугацаа, ниймгийн харилцаатай холбоотой уг хуулийг төрөлжүүлэн, шинэчлэн найруулж, 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр баталж, 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Энэ хуулийн зорилго нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцох, түүнийг

үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршино.

Зөрчлийн тухай хуулийн хоёр дугаар бүлгийн 2.1-д “Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчил гэнэ.” гэж хуульд тусгасан⁵¹. Мөн хуульд зөрчлийн хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тогтоож өгсөн нь энэ хуулийн ойлгомжтой, гарч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлж өгсөн давуу талтай юм. Хуульд зааснаар:

-хүнд 10-500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэнээс хойш зургаан сар өнгөрсөн;

-хүнд 500-10000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн;

-хүнд 10000-20000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэнээс хойш хоёр жил өнгөрсөн бол зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зохион байгуулахгүй.

-Баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэнээс хойш зургаан сарын хугацаа өнгөрсөн бол зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг мөн явуулахгүй.

Харин хуулийн этгээд үйлдсэн бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан торгох шийтгэлийн хэмжээг арав дахин нэмж дүйцүүлэн хөөн хэлэлцэх хугацааг

⁵¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №24

тогтоохдоо хуулийн этгээдэд шийтгэл оногдуулахаар заасан торгох шийтгэлийн хэмжээг арав дахин багасгаж энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан торгох шийтгэлийн хэмжээтэй дүйцүүлэн хөөн хэлэлцэх хугацааг тогтооно. Гэхдээ хүн, хуулийн этгээдийн хууль бус үйлдэл, эс үйлдэхүй эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй ба энэ хуулийн дагуу шийтгэл оногдуулах үндэслэлтэй бол хөөн хэлэлцэх хугацааг эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах тухай шийдвэр гарсан өдрөөс эхлэн тоолно⁵².

Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэлийн төрлүүдийг санцрын хамт дурдвал:

- торгох шийтгэл (10.000-2000.000 100.000-20.000.000)
- баривчлах шийтгэл (7-30 хоног)
- нийтэд тустай ажил хийлгэх (240-720 цаг)
- эрх хасах шийтгэл (3 сараас 2 жил)

Торгох, баривчлах шийтгэлийг үндсэн, нийтэд тустай ажил хийлгэх, эрх хасах шийтгэлийг нэмэгдэл шийтгэлийн хэлбэрээр оногдуулна.

- Албадагын арга хэмжээ
- Хөрөнгө, орлогыг хураах, шилжүүлэх
- Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хураах
- Хохирол, нөхөн төлбөр гаргуулах
- Албадан эмчлэх
- Албадан сургалт (10-50 цаг)⁵³

Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд зөрчил шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны харьяалал гэсэн ойлголт бий. Гарсан зөрчлийг хянан шийдвэрлэх субъектийг тодорхой тусгаж өгсөн нь энэ хуулийн мөн нэг давуу тал юм. Хуулийн заалтыг авч үзье. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д: “ахлах шийдвэр гүйцэтгэгч Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 15.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.27 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 3.1, 3.2, 3.3, 3.4, 3.5, 3.6, 3.7, 3.8, 3.9, 3.10, 3.14 дэх заалтад заасан зөрчил”⁵⁴-д зөрчлийн хэргийг шалган шийдвэрлэх ажиллагааг зохион байгуулна.

Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “Тэтгэлэг төлөгч шүүхийн шийдвэрээр сар бүр төлбөл зохих хүүхдийн тэтгэмжийг гурван сараас дээш хугацаанд төлөөгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.”

Хуулийн 15.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд нь саад учруулах гэдэгт төрийн албан хаагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсхүл биелүүлэхгүй байхыг уриалсан;

⁵² Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №24

⁵³ Мөн хуульд

⁵⁴ Төрийн мэдээлэл эмхэтгэл 2017 он, №24

төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд нь саад учруулсан; төрийн албан хаагчийг хүч хэрэглэхгүйгээр эсэргүүцсэн, эсхүл доромжилсон бол хүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж заасан нь хууль сахиулах байгууллагын алба хаагчдын чиг үүргийн дагуу үүргээ гүйцэтгэхэд эрх зүйн баталгаа болж байна.

2023 оны байдлаар төлбөрийн гүйцэтгэх хуудасны 23.3 тэрбум төгрөгийн 986 гүйцэтгэх баримт бичгийн 801.1 сая төгрөгийн төлбөр хүүхдийн тэтгэлэг гаргуулахтай холбоотой гүйцэтгэх хуудас байна. Хүүхдийн тэтгэлэгийн гүйцэтгэх баримт бичгийн статистикийг өнгөрсөн оныхтой харьцуулахад шүүхээс ирсэн 1000 гүйцэтгэх хуудсаар буюу 1089 гүйцэтгэх баримт бичгээр нэмэгдсэн дүнтэй байна. Бодит биечлсэн гүйцэтгэх хуудас 8.2 хувь байна. Энэ нь энэ төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд анхаарч, хариуцлаггүй байгаа эцэг, эхэд хариуцлага тооцох зайлшгүй шаардалгай байгааг харуулж байна.

Зөрчлийн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 3.4 дүгээр зүйлийн 7-д “7.Энэ хуулийн тусгай ангид заасны дагуу торгох шийтгэлийг сонгож оногдуулахаар заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол эрх бүхий албан тушаалтны саналаар шүүх баривчлах шийтгэлээр солино” гэж заасан нь буруутай үйлдэл эс

үйлдэхүй бүрд хариуцлага зайлшгүй оногдуулж, түүнийг гарцаагүй биелэгдэх нөхцөл боломжийг сонголттой биелэгдэх нөхцлийг бүрдүүлснээрээ онцлог юм.

Дүгнэлт

Зөрчлийн тухай хууль хэрэгжээд долоон жилийн хугацаа өнгөрсөн байна. Энэ хугацаанд зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль, журмыг судлан үзэхэд дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

Монгол улсад нэн тэргүүнд Улсын их хурлаас батлагдан гарч байгаа хуулийг ард иргэдэд суртачилан таниулах мэдээ мэдээлэл олгох ажил учир дутагдалтай байна. Үйлдэж болохгүй үйлдэл, эс үйлдэхгүйгээ мэдээгүй байхад хуулийн заалт удиртгал болгон муйхарлах нь хүний эрхийг зөрчиж байгаагийн нэгэн хэлбэр юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 143 дугаар зүйлийн 143.1.Шийтгүүлсэн этгээд хууль, эсхүл торгох шийтгэл оногдуулсан шийдвэрт өөрөөр заагаагүй бол тухайн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 90 хоногийн дотор, хэрэв хуульд зааснаар торгуулийг хэсэгчлэн төлж барагдуулахаар тогтоосон бол тогтоосон хугацаанд торгуулийг бүрэн төлж барагдуулах үүрэгтэй. Үүргээ биелүүлээгүйд нь биш, үүргийн биелэлтийг дүйцүүлэн баривчлах шийтгэл ногдуулж байгаа нь шийтгүүлсэн этгээдүүдийн хувьд хариуцлагын тогтолцоо байхгүйгээс

ухамсарлах хандлага тогтохгүй нөхцөл бий болгож байна.

Мөн хуулийн 141 дүгээр зүйлийн 141.1.Энэ хуулийн 20.3-т заасан буцаах үндэслэл байхгүй бол ахлах шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэг нээж, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх тухай тогтоол гарган зохих тойргийн шийдвэр гүйцэтгэгчид хуваарилна. Хэдий хугацаанд хянуулах ёстой нь тодорхой бус байна.

Торгох шийтгэл оногдуулсан шийтгэлийг биелүүлээгүй тохиолдолд Зөрчлийн тухай хуульд баривчлах шийтгэл солих саналыг эрх бүхий албан тушаалтан гэж заасан бол Улсын ерөнхий прокурорын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих прокурорын зааварт 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/30 тушаалаар нэмэлт өөрчлөлт орсны дагуу шийдвэр гүйцэтгэгч санал гаргаж байна. Энэ нь шүүхийн байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагааны үед эргэлзээ бүхий нөхцөл үүсэх боломжтой байна.

Санал

Зөрчилд тооцох үйлдэл, эс үйлдэхүй болон батлагдан гарсан хуулийг хэрэгжүүлэхийн өмнө хуулийг ард иргэдэд хүртээмжтэй хууль суртачилах ажиллагааг үр дүнтэй төрөөс зохион байгуулсны дараа мөрдөж эхлэх.

Зөрчлийн тухай хуулиар шийтгэл хүлээсэн этгээд хариуцлагаа сайн дураараа биелүүлэхгүй байгаа нь гэм буруугаа ухамсарлахгүй байна гэж үзэх нэг шалтгаан болно. Шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй болон мөн үүргээ биелүүлэггүй нь дахин хариуцлага хүлээлгэх боломжтой.

Ахлах шийдвэр гүйцэтгэгч шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 141-д заасан ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаад хэдий хугацаанд прокурорын байгууллагад хянуулах хугацааг тодорхой тусгаж өгөх.

Баривчлах шийтгэл солих саналыг гаргах субъектыг тодорхой болгох.

Шүүхээс шүүхийн шийдвэрээр шийтгэл хүлээсэн этгээдтэй нь хүлээн авдаг эрх зүйн зохицуулалт бий болгох.

Ашигласан эх сурвалж

- Төрийн мэдээлэл эмхэтгэл
2017 он, №24

- Зөрчлийн тухай хууль

- Зөрчил шалган шийдвэрлэх
тухай хууль

- Прокурорын тухай хууль

- Ю.Оюунаа Зөрчлийн шийдвэр
гүйцэтгэх ажиллагаа УБ., 2021. 7 дахь
тал

- Монгол хэлний тайлбар толь
<http://mongoltoli.mn>